



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 184/ШШ2019/00571

Улаанбаатар хот

Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг
баталж хэргийг хэрэгсэхгүй болгох тухай

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
Э.Амин-Эрдэнэ би

Нэхэмжлэгч: Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж,
Ньюдаймайнд Групп ХХК-ийн байранд байрлах, “Лэндмн ББСБ” ХК /РД:5039754/-
ийн нэхэмжлэлтэй,

Хариуцагч: Сонгинохайрхан дүүрэг, 13 дугаар хороо, 8 дугаар байр, 00 тоот
хаягт оршин суух, Сартуул овогт Энхтайваны Отгон-Эрдэнэ /РД:ГЭ88072710/-д
холбогдох

Зээлийн гэрээний үүрэгт 270,100 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийг 2019
оны 02 дугаар сарын 14-ний өдөр хүлээн авч, 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдөр
иргэний хэрэг үүсгэн хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгч “Лэндмн ББСБ” ХК шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ:

... Э.Отгон-Эрдэнэ нь Иргэний хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн
хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай болон өөрийн
хүсэлтийн дагуу “Лэндмн ББСБ” ХК –тай 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр
42308 дугаартай Цахим зээлийн эрх нээх гэрээг байгуулсан. “Лэндмн ББСБ” ХК
зээлдэгч Э.Отгон-Эрдэнийн Lendmn аппликейшнээр дамжуулан гаргасан
хүсэлтийн дагуу 2018 оны 05 дугаар сарын 11-ний өдөр 250,000 төгрөгийн
зээлийг 11,100 төгрөгийн шимтгэлтэй, 30 хоногийн хугацаатай, 2018 оны 06
дугаар сарын 10-ны өдөр бүрэн эргэн төлөх нөхцөлтэй, 250,000 төгрөгийг
Э.Отгон-Эрдэнийн Хаан банкны 5029983650 тоот дансанд шилжүүлсэн.
Зээлдэгч Э.Отгон-Эрдэнэ үндсэн зээлийн дүн болох 250,000 төгрөг, шимтгэл
болох 11,100 төгрөгийг өнөөдрийг хүртэл төлөөгүй байна. Зээлдэгч нь зээлийн
гэрээний 4.2.2 заалтыг зөрчин, зээлийг хугацаанд нь эргэн төлөх үүргээ
биелүүлээгүй байна. Э.Отгон-Эрдэнийн гэрээний үүргээ биелүүлэх, зээлээ
төлөхийг удаа дараа шаардсан боловч эргэн төлөлтийг өнөөдрийг хүртэл
төлөөгүй байгаа тул хариуцагч Э.Отгон-Эрдэнээс үндсэн зээлийн төлбөр
250,000 төгрөг, зээлийн шимтгэл 11,100 төгрөгийг гаргуулах хүсэлтэй байна.
Иймд хариуцагч Э.Отгон-Эрдэнээс үндсэн зээлийн төлбөр 250,000 төгрөг
шимтгэл 11,100 төгрөг, нотариатын үйлчилгээний төлбөр 9,000 төгрөг буюу нийт
270,100 төгрөгийг гаргуулж өгнө үү гэжээ.

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Билгүүн шүүхэд гаргасан
хүсэлтдээ:

...Хариуцагч Э.Отгон-Эрдэнэ нь "Лэндмн ББСБ" ХК-иас авсан зээлийн төлбөрийг барагдуулж дууссан тул нэхэмжлэлээсээ татгалзаж байна. Иймд хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж өгнө үү гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Нэхэмжлэгч "Лэндмн ББСБ" ХК нь хариуцагч Э.Отгон-Эрдэнэд холбогдуулан зээлийн гэрээний үүрэгт 270,100 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг тус шүүхэд гаргажээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1-д Хэрэг үүсгэснээс хойш шүүх хуралдаан хүртэлх хугацаанд нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан... бол хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэнэ, 74.2-д Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх боломжтой гэж үзвэл шүүгч нэхэмжлэгчийн татгалзалыг... баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай захирамж гаргана гэж тус тус заажээ.

Нэхэмжлэгч "Лэндмн ББСБ" ХК -ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь ..хариуцагч Э.Отгон-Эрдэнэ нь нэхэмжлэлийн шаардлага 270,100 төгрөгийг бүрэн төлж, нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлсэн гэх үндэслэлээр нэхэмжлэлээсээ татгалзаж байгаа нь хуулийн дээрх зүйл, заалтад нийцэх тул шүүх нэхэмжлэгчийн татгалзалыг баталж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй гэж үзэв.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 75 дугаар зүйлд заасныг удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэгт зааснаар Э.Отгон-Эрдэнэд холбогдох зээлийн гэрээний үүрэгт 270,100 төгрөг гаргуулах тухай "Лэндмн ББСБ" ХК -ийн нэхэмжлэлтэй иргэний хэрэгт нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.5-д зааснаар нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 8,753 төгрөгөөс 4,376.5 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээж, 4,376.5 төгрөгийг Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн 2601025961 тоот данснаас гаргуулан "Лэндмн ББСБ" ХК-д олгосугай.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4 дэх хэсэгт зааснаар зохигч давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүйг тайлбарласугай.

ШҮҮГЧ



Э.АМИН-ЭРДЭНЭ